

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг «*Studia Philosophiae Et Juris / Философи, эрх зүйн судлал*» сэтгүүл нь 1976 оноос тогтмол хэвлэгдсээр 48 дахь жилдээ энэ удаагийн (39 дэх) дугаараа уншигч таны гарт хүргэж байна.

Тус «*Studia Philosophiae Et Juris / Философи, эрх зүйн судлал*» эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл нь анхлан гарсан цагаасаа хойш философи, социологи, төр эрх, шашин, шинжлэх ухаан судлалын болон улс төр судлалын чиглэлээр тухайн цаг үеийнхээ чухал асуудлуудыг өнөөдрийг хүртэл нийтэлж ирсэн түүхтэй. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн үеийг эргэн дурсаж дүгнэж, өнөөдрөө цэгнэн тунгааж ирээдүйгээ зураглахуй нь гурван цагийн залгамж дор аливаа зүйлийн мөн чанар болоод дараа дараагийн үедээ уламжлагдан үлддэг сонголт байдгийг мартаж ёсгүй. Тиймээс, бид туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, түүнээс сургамж авч, судалгаа шинжилгээний ажлаа улам чамбайруулах нь бидний өмнөө тавьсан гол зорилт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийн маань суурь байх боломжтой.

Шинжлэх ухааны уламжлалт бүтэц, зохион байгуулалтын бүрдэл нь үндсэндээ судалгаа, хамтынажиллагааг

хялбаршуулах, эсвэл санаатай болон санамсаргүй зорилтод чиглүүлэхэд оршдог гэж болно. Чухам иймээс шинжлэх ухааны хоршсон хүрээ нь ямар нэгэн зугаа цэнгэл төдийхнөөр бус аливаад тууштай, бүтээлчээр хандаж гэмээ нь өөрийн мөрөн дээрх том саад бэрхшээлийг даван туулаад зогсохгүй агуу том амжилтыг бүтээн цогцлуулах боломжтой. Ингэхийн тулд аливаад бүтээлчээр хандаж, хичээл зүтгэлтэй байсны эцэст түүнийхээ үр шимийг хүртэж чаддаг байх нь бидний шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр төдийгүй дараагийн үеийнхэндээ өртөөлөн түүчээлэх их эрч хүч гэж болно.

Бидний толилуулан буй энэхүү сэтгүүлийн зорилго маань нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны орчин үеийн судалгааны чиг хандлага, ололт амжилт, үр дүнг таниулах, онол-арга зүйн түвшин, чанарыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэхэд чиглэсэн эрдэм судлалын ажлын талбар байхад чиглэгдэнэ.

Нөгөөтээгүүр сэтгүүлийн нийтлэлийн бодлого ч философи, социологи, улс төр судлал, шашин судлал, эрх зүй, бодлого судлал, улс төрийн эдийн засгийн ухааны чиглэлээрх дагнасан болон шинжлэх ухааны салбар дундын онол, практикийн асуудлыг судлан

тодорхойлох, судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах, нийтэд түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Сэтгүүлийн энэхүү дугаарт манай философич, социологич, эрх зүйч, улс төр, шашин судлаач эрдэмтдийн бичсэн өгүүлэл, тэдгээрт дэвшигдсэн

эрдэм шинжилгээний шинэлэг санаа та бүхний оюуны мэлмийг нээж, судалгаа, шинжилгээний бүтээлч санаачилга, бүтээн туурвих их сэдлийг төрүүлэхэд тань чухал хувь нэмэр оруулна гэдэгт гүнээ итгэж байна.

Номын хутаг ашид мөнх оршин, аригдаж байхын ерөөлийг дэвшүүлье.

*Доктор (Ph.D), профессор Б.ПҮРЭВСҮРЭН  
Сэтгүүлийн эрхлэгч, ерөнхий редактор*